



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/183

Даланзадгад сум

Тохиолдлын удирдлагын баг
томилох тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалт, Монгол улсын Шадар сайдын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тушаал, 2024 оны А/437 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдлын удирдлагын багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тохиолдлын удирдлагын багт томилогдсон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/437 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, нэгдсэн мэдээлэл, удирдлага арга зүй, зохион байгуулалтаар хангаж, бэлтгэл бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллахыг тохиолдлын удирдлагын тогтолцооны зохицуулагч, Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга (Б.Ганшагай), Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга (Б.Амгалан), эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмнэлзүй, ор зохицуулалтыг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга (Ж.Отгонбайгаль), хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, хүний нөөцийн бэлэн байдлыг ханган томилгоожуулж, ажлын сахилга бат, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг нягтлан эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт сурталчилгаа, зөвлөгөө, зөвлөмжийг тогтмол хүргэж ажиллахыг бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Оюунсүрэн)-д, Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Цагаанцэнд) нарт тус тус даалгасугай.


ДАРГА

Ц.ЖАВЗАНДУЛАМ



462491491

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн
А/83 дугаар тушаалын хавсралт



ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Тохиолдлын удирдлагын багийн дарга: - ЭМГ-ын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга
- Тохиолдлын удирдлагын багийн дэд дарга: - ЭМГ-ын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
- Нарийн бичиг: - ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Төлөвлөлтийн багийн дарга: - ЭМГ-ын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
- Төлөвлөлтийн багийн гишүүд:
- ЭМГ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга
 - ЭМГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга
 - ЭМГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн дарга
 - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал
 - Зоонозын өвчин судлалын төвийн дарга
 - Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар
 - Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын холбооны тэргүүн
- Эрсдэлийн харилцааны багийн дарга: - Хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн хэлтсийн дарга
- Гишүүд: - ЭМГ-ын Мэдээллийн технологи хариуцсан ажилтан
- БОЭТ-ийн Мэдээллийн технологи хариуцсан ажилтан
- Шуурхай хариу арга хэмжээний багийн дарга:
- ЭМГ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмнэлзүйн асуудал хариуцсан гишүүд:
- БОЭТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
 - ЭМГ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
 - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга
 - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн эмч
 - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын эмч
 - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Лабораторийн эмч
 - Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар
 - Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч
- Тархвар судлалын тандалт болон халдварын сэргийлэлт хяналт хариуцсан гишүүд:
- Эрүүл мэндийн газрын Халдвар судлаач
 - Эрүүл мэндийн газрын Орчны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдвар судлаач

Дархлаажуулалт хариуцсан гишүүн:

- ЭМГ-ын Дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
- ЭМГ-ын Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн вакцинолог сувилалч

Нөөц санхүүгийн багийн дарга:

- Эрүүл мэндийн газрын Эдийн засагч

Гишүүд:

- Эрүүл мэндийн газрын Ерөнхий нягтлан бодогч
- Эрүүл мэндийн газрын Эмийн чанар, аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүний нөөцийн албаны дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмзүйн албаны дарга
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Нягтлан бодогч
- Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ерөнхий нягтлан

oOo